# ХААН СОЁМБО АУДИТ ХХК

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2023/34/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2023 он


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт....3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....11

3. Аудитын тайлан....12

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа....12

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин....12

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....13

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд....13

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....14

4. АУДИТЫН ТАЙЛАН....15

4.1 Ерөнхий зүйл....15

4.2 Материаллаг байдал....15

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт....15

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....15

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....15

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**....16

**4.5.1 Завсрын аудитын талаар**....16

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**....16

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....16

3.8 Аудитын гол асуудал....16

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....16

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16

4. Аудитын илрүүлэлт....16

4.1 Залруулсан алдаа....16

4.2 Төлбөрийн акт....16

4.3 Албан шаардлага....16

4.4 Зөвлөмж....16

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....16

## Товчилсон үгийн жагсаалт

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.15 № 01/67
танай ____________ -ны № ____________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.РАДНААБҮД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 101.3 сая төгрөгөөр буюу 6.2 хувиар буурсан байна.

**Аудитын гол асуудал**

Туслах үйл ажиллагааны орлогоос оруулах төлөвлөгөөг 35.2 сая төгрөгөөр тасалсан байна. Улсын төсвөөс авах санхүүжилтийг 4.7 сая төгрөгийг дутуу хүлээн авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2022 онд 2 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас 90.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний

баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **89,673,098.03** | **97,027,570.03** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 89,673,098.03 | 97,027,570.03 |
| **354** | **Хангамжийн материал** | 89,673,098.03 | 97,027,570.03 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,379,410.03 | 24,365,410.03 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 12,749,888.00 | 5,655,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 3,958,168.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 52,543,800.00 | 63,048,992.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,521,271,609.09** | **1,412,672,339.27** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,521,271,609.09 | 1,412,672,339.27 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,390,823,509.05 | 1,283,261,189.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,124,657,995.99 | 1,124,657,995.99 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -107,358,591.91 | -141,550,475.47 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 188,049,875.00 | 188,049,875.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -146,949,875.00 | -164,233,208.24 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 302,503,642.52 | 316,149,104.88 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -122,892,400.20 | -177,960,187.70 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 111,073,240.00 | 122,631,868.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -65,006,009.03 | -80,472,252.75 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 141,013,684.51 | 141,013,684.51 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -34,268,052.83 | -45,025,215.71 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 130,448,100.04 | 129,411,150.16 |
| 39301 | Програм хангамж | 9,801,900.00 | 9,801,900.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,299,999.96 | -4,250,949.84 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 121,946,200.00 | 123,860,200.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,610,944,707.12** | **1,509,699,909.30** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,610,944,707.12** | **1,509,699,909.30** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,610,944,707.12 | 1,509,699,909.30 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 121,946,200.00 | 123,860,200.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 121,946,200.00 | 123,860,200.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,414,363,963.47 | 1,311,205,165.65 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,414,363,963.47 | 1,414,363,963.47 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -103,158,797.82 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 74,634,543.65 | 74,634,543.65 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,610,944,707.12** | **1,509,699,909.30** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,149,302,500.00** | **1,320,862,418.96** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **288,027,700.00** | **348,720,035.96** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 288,027,700.00 | 348,720,035.96 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 288,027,700.00 | 323,515,945.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 130,462,000.00 | 323,122,403.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 157,565,700.00 | 393,542.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө | 00.00 | 25,204,090.96 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **861,274,800.00** | **972,142,383.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 848,639,800.00 | 869,807,817.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 848,639,800.00 | 869,807,817.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,635,000.00 | 102,334,566.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 6,600,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 29,355,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,000,000.00 | 69,847,836.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35,000.00 | 3,131,530.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,126,200,504.89** | **1,424,021,216.78** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,126,200,504.89** | **1,424,021,216.78** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,094,296,975.64 | 1,382,102,376.16 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 650,109,221.83 | 673,916,130.11 |
| 210101 | Үндсэн цалин | 504,298,112.83 | 520,939,428.53 |
| 210102 | Нэмэгдэл | 121,618,615.00 | 117,454,143.29 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,192,494.00 | 29,959,868.29 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 5,562,690.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,240,020.00 | 88,136,328.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,095,774.35 | 60,879,757.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,755,225.55 | 6,988,518.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,263,059.79 | 5,397,798.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,284,180.23 | 1,318,501.48 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,841,780.08 | 13,551,751.65 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 60,949,515.51 | 56,896,242.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,602,448.23 | 10,005,284.17 |
| 210302 | Түлш, халаалт | 44,937,554.52 | 41,411,253.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,409,512.76 | 5,479,704.27 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 35,469,653.56 | 45,275,939.29 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,211,200.00 | 12,143,080.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,352,650.00 | 11,205,550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,597,818.56 | 2,102,998.29 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,130,400.00 | 1,297,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,226,045.00 | 12,932,161.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,951,540.00 | 5,594,350.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 52,899,733.00 | 152,931,592.10 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,157,300.00 | 356,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 51,532,433.00 | 152,575,292.10 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 210,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,773,000.00 | 10,548,336.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 1,616,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,773,000.00 | 8,932,336.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 146,000.00 | 1,820,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 146,000.00 | 1,820,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 77,425,134.85 | 170,734,047.65 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 76,049,677.85 | 167,411,202.65 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 247,200.00 | 247,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 235,642.00 | 235,642.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 88,000.00 | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 346,500.00 | 1,489,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 458,115.00 | 543,003.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 126,284,696.89 | 181,843,760.78 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 46,126,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 126,284,696.89 | 135,717,360.78 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31,903,529.25 | 41,918,840.62 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,180,846.00 | 36,380,470.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,229,654.00 | 27,646,617.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 951,192.00 | 8,733,853.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 14,722,133.25 | 5,538,370.62 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,722,133.25 | 5,538,370.62 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,000,550.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,000,550.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **23,101,995.11** | **-103,158,797.82** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 21,654.76 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 21,654.76 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -21,654.76 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **23,080,340.35** | **-103,158,797.82** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **991,736,800.00** | **1,295,264,786.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **130,462,000.00** | **323,122,403.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 130,462,000.00 | 323,122,403.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 130,462,000.00 | 323,122,403.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 130,462,000.00 | 323,122,403.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **861,274,800.00** | **972,142,383.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 848,639,800.00 | 869,807,817.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 848,639,800.00 | 869,807,817.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,635,000.00 | 102,334,566.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 6,600,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 29,355,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,000,000.00 | 69,847,836.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 35,000.00 | 3,131,530.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **986,236,800.00** | **1,295,264,786.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **986,236,800.00** | **1,295,264,786.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **954,333,270.75** | **1,253,345,945.38** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 650,109,221.83 | 673,916,130.11 |
| 210101 | Үндсэн цалин | 504,298,112.83 | 520,763,309.26 |
| 210102 | Нэмэгдэл | 121,618,615.00 | 117,630,262.56 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,192,494.00 | 29,959,868.29 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 5,562,690.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,240,020.00 | 88,136,328.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,035,869.14 | 60,879,757.92 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,681,613.62 | 6,988,518.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,258,030.84 | 5,397,798.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,296,682.44 | 1,318,501.48 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,967,823.96 | 13,551,751.65 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 53,621,403.51 | 45,805,549.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,602,448.23 | 10,005,284.17 |
| 210302 | Түлш, халаалт | 37,609,442.52 | 30,020,560.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,409,512.76 | 5,779,704.27 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,303,613.56 | 39,134,639.29 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,211,200.00 | 12,143,080.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,292,650.00 | 11,143,950.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,597,818.56 | 2,102,998.29 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,130,400.00 | 1,297,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,071,545.00 | 12,446,811.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 51,272,877.00 | 158,333,760.10 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,038,000.00 | 356,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 50,024,877.00 | 156,533,460.10 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 210,000.00 | 1,444,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,315,000.00 | 25,281,686.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,542,000.00 | 12,009,350.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,773,000.00 | 13,272,336.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 146,000.00 | 1,820,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 146,000.00 | 1,820,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 75,325,134.85 | 174,791,452.65 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 73,949,677.85 | 171,468,607.65 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 247,200.00 | 247,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 235,642.00 | 235,642.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 346,500.00 | 1,489,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 458,115.00 | 543,003.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 00.00 | 46,126,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 46,126,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,903,529.25** | **41,918,840.62** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,180,846.00 | 36,380,470.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,229,654.00 | 27,646,617.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 951,192.00 | 8,733,853.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 15,722,683.25 | 5,538,370.62 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,722,133.25 | 5,538,370.62 |
| 213304 | Хөрөнгийн | 1,000,550.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **5,500,000.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,500,000.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,500,000.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 5,500,000.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,500,000.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-5,500,000.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 123,346,200.00 | 74,634,543.65 | 1,499,741,937.08 | 1,697,722,680.73 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **123,346,200.00** | **74,634,543.65** | **1,499,741,937.08** | 1,697,722,680.73 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -78,237,026.17 | -78,237,026.17 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **121,946,200.00** | **74,634,543.65** | **1,414,363,963.47** | 1,610,944,707.12 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **121,946,200.00** | **74,634,543.65** | **1,414,363,963.47** | 1,610,944,707.12 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **121,946,200.00** | **74,634,543.65** | **1,414,363,963.47** | 1,610,944,707.12 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 1,914,000.00 | 00.00 | 00.00 | 1,914,000.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -103,158,797.82 | -103,158,797.82 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **123,860,200.00** | **74,634,543.65** | **1,311,205,165.65** | 1,509,699,909.30 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,236,291,200.00 | 1,190,826,358.88 | -45,464,841.12 | 96.32 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,236,291,200.00 | 1,190,826,358.88 | -45,464,841.12 | 96.32 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,196,802,700.00 | 1,159,545,888.88 | -37,256,811.12 | 96.89 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 673,972,700.00 | 673,916,130.11 | -56,569.89 | 99.99 |
| 210101 | Үндсэн цалин | 509,342,400.00 | 520,763,309.26 | 11,420,909.26 | 102.24 |
| 210102 | Нэмэгдэл | 140,347,600.00 | 117,630,262.56 | -22,717,337.44 | 83.81 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,282,700.00 | 29,959,868.29 | 5,677,168.29 | 123.38 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 5,562,690.00 | 5,562,690.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,668,500.00 | 88,136,328.19 | -532,171.81 | 99.40 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,729,800.00 | 60,879,757.92 | 149,957.92 | 100.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,984,700.00 | 6,988,518.97 | 3,818.97 | 100.05 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,587,800.00 | 5,397,798.17 | -190,001.83 | 96.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,396,900.00 | 1,318,501.48 | -78,398.52 | 94.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,969,300.00 | 13,551,751.65 | -417,548.35 | 97.01 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45,523,300.00 | 45,505,549.04 | -17,750.96 | 99.96 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,968,100.00 | 10,005,284.17 | 37,184.17 | 100.37 |
| 210302 | Түлш, халаалт | 29,892,700.00 | 30,020,560.60 | 127,860.60 | 100.43 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,662,500.00 | 5,479,704.27 | -182,795.73 | 96.77 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,645,200.00 | 26,038,279.29 | -2,606,920.71 | 90.90 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,855,900.00 | 1,621,400.00 | -234,500.00 | 87.36 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,895,800.00 | 8,895,800.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,438,100.00 | 2,102,998.29 | -2,335,101.71 | 47.39 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,556,200.00 | 1,297,800.00 | -1,258,400.00 | 50.77 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,899,200.00 | 12,120,281.00 | 1,221,081.00 | 111.20 |
| **2105** | **Нормативт зардал** | 158,166,600.00 | 155,960,299.60 | -2,206,300.40 | 98.61 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,200,000.00 | 356,300.00 | -843,700.00 | 29.69 |
| 210502 | Хоол, хүнс | 154,160,000.00 | 154,159,999.60 | -0.40 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,806,600.00 | 1,444,000.00 | -1,362,600.00 | 51.45 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,447,100.00 | 17,845,850.00 | -601,250.00 | 96.74 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,115,100.00 | 12,009,350.00 | -105,750.00 | 99.13 |
| 210604 | Урсгал засвар | 6,332,000.00 | 5,836,500.00 | -495,500.00 | 92.17 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 62,400.00 | 00.00 | -62,400.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 62,400.00 | 00.00 | -62,400.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 183,316,900.00 | 152,143,452.65 | -31,173,447.35 | 82.99 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 179,229,400.00 | 148,820,607.65 | -30,408,792.35 | 83.03 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 720,000.00 | 0.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 571,600.00 | 247,200.00 | -324,400.00 | 43.25 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 302,500.00 | 235,642.00 | -66,858.00 | 77.90 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 88,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,551,600.00 | 1,489,000.00 | -62,600.00 | 95.97 |
| 210807 | Газрын төлбөр | 853,800.00 | 543,003.00 | -310,797.00 | 63.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 39488500.00 | 31280470.00 | -8,208,030.00 | 79.21 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 39,488,500.00 | 31,280,470.00 | -8,208,030.00 | 79.21 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 35,790,000.00 | 27,646,617.00 | -8,143,383.00 | 77.25 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,698,500.00 | 3,633,853.00 | -64,647.00 | 98.25 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,236,291,200.00 | 1,190,826,358.88 | -45,464,841.12 | 96.32 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 877,951,200.00 | 867,703,955.88 | -10,247,244.12 | 98.83 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 877,951,200.00 | 867,703,955.88 | -10,247,244.12 | 98.83 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 358,340,000.00 | 323,122,403.00 | -35,217,597.00 | 90.17 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 358,340,000.00 | 323,122,403.00 | -35,217,597.00 | 90.17 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 58.00 | 58.00 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 48.00 | 48.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 09.00 | 09.00 | 0.00 | 100.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **58.00** | **58.00** | 0.00 | 100.00 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 47.00 | 47.00 | 0.00 | 100.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 11.00 | 11.00 | 0.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |

| | | |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **102,334,566.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **102,334,566.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 93,800,056.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 300,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,096,360.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,521,680.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,248,150.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 326,530.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,373,460.50 |
| 210502 | Хоол, хүнс | 2,373,460.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,435,836.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,435,836.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,820,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,820,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 22,648,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,648,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 46126400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 46,126,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5100000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,100,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,100,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **3,434,509.50** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 3,434,509.50 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 102334566.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 102,334,566.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 29,355,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 69,847,836.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,131,530.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь төрөөс баримталж буй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн бодлого зохицуулалтыг нягт уялдуулж, хууль журам, ёс зүйг баримтлан, төрийн үйлчилгээг зорилтот бүлгийн өрх, иргэнд чанартай, шуурхай хүргэх үүрэгтэй байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь байгууллагын дотоод хяналт хэрэгжүүлэхдээ дараах журам, зааврын дагуу ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/121 дүгээр тушаалаар батлагдсан "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу хийж байна.

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг оновчтой төлөвлөхийн тулд аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголттой болсон. Дотоод хяналтын бүрэлдэхүүн хэсгийн талаар судалж эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 101.3 сая төгрөгөөр буюу 6.2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Дансны авлага | - | - | - |
| Бараа материал | 89.6 | 97.0 | 7.4 |
| Үндсэн хөрөнгө | 1521.2 | 1412.6 | (108.6) |
| Биет бус хөрөнгө | 130.4 | 129.4 | (1) |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | **1610.9** | **1509.6** | (101.3) |
| Дансны өглөг | - | - | - |
| -төрийн | 121.9 | 121.9 | - |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 74.6 | 74.6 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 1414.3 | 1313.1 | (101.2) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1610.9** | **1509.6** | (101.3) |

Тайлант онд дараах данстад өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Бараа материал 7.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авч бэлтгэсэн бараа материалын үлдэгдэл нөлөөлсөн байна.
2. Үндсэн хөрөнгө данс 108.6 сая төгрөгөөр багассан нь тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нөлөөлсөн.
3. Хуримтлагдсан үр дүн 101.2 сая төгрөгөөр багассан нь тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,034.9 сая, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 358.3 сая төгрөг, нийт зарлагыг 1,313.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,236.3 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 877.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 358.3 сая төгрөг, нийт 1,236.2 сая төгрөгийг баталсан байна. Туслах үйл ажиллагааны орлогоос оруулах төлөвлөгөөг 35.2 сая төгрөгөөр тасалсан байна. Улсын төсвөөс авах санхүүжилтийг 4.7 сая төгрөгийг дутуу хүлээн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,190.7 сая төгрөг буюу 96.3 хувьтай байгаа ба 5.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

*Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал*

/сая төгрөгөөр/

| Хөтөлбөр, арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **71902** | **Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар** | **1,236.2** | **1,190.7** | **45.4** | **96.2** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 838.5 | 836.4 | 2.1 | 98.8 |
| 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ | 358.3 | 323.1 | 35.2 | 90.2 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 39.4 | 31.2 | 8.1 | 79.2 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан 32.4 сая төгрөгийн нэмэлт орлого хүлээн авч тайлагнасан байна.

Үүнээс: Хичээл үйлдвэрлэлийн зардалд 23.8 сая төгрөг, албан томилолтын зардалд 0.54 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардалд 5.1 сая төгрөг, хоол хүнсэнд 2.3 сая төгрөг, цэвэр бохир усны зардалд 0.3 сая төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 0.35 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, хяналтыг аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 22.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 15.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

Хангамж бараа материалын зардлаас 2.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрөөс 31.4 тус тус хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 2022 онд санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал "автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норматив"-ыг мөрдөн, хэрэгжүүлж ажиллах талаар 1 зөвлөмжийг өгч, тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 0.1 | 1 | 0.1 | 100 |
| **Нийт дүн** | **1** | 0.1 | **1** | **0.1** | 100 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

## 5. Аудитын илрүүлэлт

Туслах үйл ажиллагааны орлогоос оруулах төлөвлөгөөг 35.2 сая төгрөгөөр тасалсан байна.

Аудитаар 37.1 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 1.9 сая төгрөгийн алдааг залруулж, 35.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Дараах алдааг залруулсан. Үүнд: ХХҮГ нь тайлант онд 1.9 сая төгрөгийн газар эзэмших эрхийг орлогод авахдаа засгийн газрын санг нэмэгдүүлэхгүйгээр үндсэн үйл ажиллагааны орлогоор тайлагнасан нь УСНББОУС-17, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал болон НББББ-тэй нийцэхгүй байна.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Туслах үйл ажиллагааны орлогыг 35.2 сая төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” заалтыг зөрчсөн ба “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Туслах үйл ажиллагааны орлогыг бүрэн бүрдүүлж ажиллах.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| НББББББ-тэй холбоотой алдаа | 1 | 1.9 | - | - | 1 | 1.9 | 1 | 1.9 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Туслах үйл ажиллагааны орлого дутуу төвлөрүүлсэн | 1 | 35.2 | - | - | - | - | 1 | 35.2 | | | | |
| Дүн | 1 | 35.2 | - | - | - | - | 1 | 35.2 | - | - | - | - |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

***ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:***

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

***АНХАН ШАТАНД ХЯНАСАН:***

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР Б.ДАВААНЯМ ОГНОО:

***БАТАЛГААЖУУЛСАН:***

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Х.ДИЙМАА

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АХЛАХ АУДИТОР Н.БАДАМХАНД

УЛААНБААТАР ХОТ
ХААН СОЁМБО АУДИТ ХХК
ШТК0364 6697798
9021091402